

Төсөл хэрэгжүүлэгч:
“МАНДАЛТ КОНСТРАКШН” ХХК

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАДАЛ СУМЫН НУТАГ
ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИХ
“ЧИНГИС ХААН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЦОГЦОЛБОР”ТӨСЛИЙН
2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Улаанбаатар хот
2025 он

Батлав: БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын дарга

.....Г.Энхмөнх

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:
“Мандалт констракшн” ХХК ийн захирал



ХЭНТИЙ АЙМГИЙН ДАДАЛ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИХ
“ЧИНГИС ХААН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР”ТӨСЛИЙН

2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 546803/

Хянасан: БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн

.....

Боловсруулсан:

“Мандалт Констракшн” ХХК –ийн байгаль орчны мэргэжилтэн

.....Б.Урангоо

Улаанбаатар

2025 он

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1 Төслийн товч танилцуулга	2
1.2 Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт	4
1.3 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....	5
БҮЛЭГ II. ТУХАЙН ЖИЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	6
2.1 Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт.....	6
2.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	7
2.3 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	10
2.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө.....	11
2.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	12
2.6 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	14
2.7 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	15
2.8 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	16
2.9 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах	17

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн товч танилцуулга

Удиртгал: Азийн хөгжлийн банкны санхүүжилттай Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны захиалгаар хийгдэж буй “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл” нь Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газар, (ХУТХГ) болон Онон-Балжийн байгалийн цогцолборт газар (ОББЦГ)-т үндэсний жишиг зорин очих газрыг бий болгохыг зорьж байна.

Төслийн зорилго: Монголын Эзэнт гүрнийг үүсгэн байгуулагч, монгол үндэстний эв нэгдэл, сэргэн мандлыг дэлхий дахинаа тунхаглан зарласан аугаа их Чингис хааны эрдэм билэг, суу заль, энэрэхүйн ёс, хосгүй авьяас чадварыг дэлхий дахинд үнэн зөвөөр таниулах.

Төслийн ач холбогдол: Эзэн Чингис хааны түүхэн гавьяаг олон улсад үнэн зөвөөр таниулах, Монголын Эзэнт гүрэн, Алтан ургийн хаадын түүхийг өгүүлэх, төрт ёсны өв уламжлалыг таниулах, сурталчлахад цогцолборын түүхэн ач холбогдол оршино.


Ерөнхий төлөвлөлтийн концепци онцлог шинж:

Ерөнхий төлөвлөгөөний концепцийг Онон-Балжийн голын хөндийд хамрагдаж байгаа үзэсгэлэнт байгаль болон талбайн зүүн хэсэгт урсах голын хөндий зэрэг байгалийн тогтцыг байгаа байдлаар нь хадгалан үлдээх, ирсэн зочид жуулчдад аливаа том хэмжээний барилга байгууламжийг үзүүлэх бус түүхэн дурсгалт газрын онгон тагшин газрыг байгаагаар нь үзүүлэхэд гол зорилгоо болгосон.

Дэлүүн болдог, Эрчист овоо, Хажуу булаг гэсэн гол түүхэн дурсгалт газруудыг Мэдээллийн төв болон Бортолгойд шинээр баригдах Тэнгэрийн Орд зэрэг байгууламжуудтай холбоо үүсгэн тэдгээрийг явган болон цахилгаан хөсгийн замаар холбож, мөн төлөвлөлтийн хилийн баруун талын нарсан ой дотор жуулчдын явган зугаалга хийх ердийн замтай холбосон болно.

Гадаад дотоодын жуулчдын хамгийн түрүүнд ирэх газар нь мэдээллийн төвийн хажууд байрлах автомашины зогсоол байх ба тэдгээр автомашинууд цогцолборын эдэлбэр газрын хүрэн дотор зорчих боломж хаалттай байна. Нийт гол болон зүүн, баруун гэсэн 3 нэвтрэх хэсэгтэй байхаар төлөвлөсөн.

Сумын төвийн хил хязгаарт ойрхон урд болон зүүн урд хэсэгт бафер бүс буюу хамгаалалтын бүсийг хамгаалалтад авахаар тооцоолсон. Дээрх төлөвлөлтийн зурган дээр үзүүлсэнчлэн явган болон цахилгаан автомашины замын дагуу ариун цэврийн болон амрах байгууламжуудыг давталттайгаар төлөвлөсөн болно.



Архитектур төлөвлөлтийн шийдэл:

Хүснэгт 1. Ерөнхий төлөвлөгөөний бүрдэл

Зам талбайн бүрдэл:

1. Асфальт бетон зам
2. Цахилгаан авто машины зам / экогрид/
3. Явган хүний зам / Байгалийн боржин чулуу/

1.2 Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

Уур амьсгал: Дадал сумын цаг уурын станцын 1981-2015 оны хэмжилтээс үзэхэд агаарын температурын олон жилийн дундаж нь 0.2°C байна. Судалгааны талбай орчимд хамгийн дулаан жил нь 2007 он бөгөөд агаарын жилийн дундаж температур 2.31°C , хамгийн хүйтэн жил 1985 он бөгөөд агаарын жилийн дундаж температур -1.6°C байна.

Сарын олон жилийн дундаж явцыг авч үзвэл хамгийн хүйтэн үе болох 1-р сарын олон жилийн дундаж утга нь -19.5°C , хамгийн дулаан үе болох 7-р сарын олон жилийн дундаж утга нь 17.69°C байдаг. Хөрсний улирлын хөлдөлт нь 10 сарын сүүлч 11 сарын эхээр эхлэн 4 сар хүртэл үргэлжилнэ. 4, 5-р сараас эхлэн улирлын хөлдөлт гэсэж эхэлдэг. Хөрсний температур 7-р сард 23.4°C , 1-р сард -23.3°C байна.

Агаарын чийгшил Жилийн дундаж харьцангуй чийгшил 32-83% хүрч, хамгийн хуурай хаврын улиралд 47-50% байна. Үнэмлэхүй чийгшлийг агаар дахь усны уурын даралтаар илэрхийлнэ. Дадал суманд үнэмлэхүй чийгшил жилийн дундаж байдлаар 5.68 7.01 гПа байна. Агаарын чийгшил нь жилийн 4 улирлын температур, хур тунадас зэргийн горимоос хамаарч өөрчлөгдөж байдаг.

Хур тунадас Дадал сумын нутагт жилдээ 170.8-672.6 мм орчим хур тунадас орох бөгөөд хамгийн бага утга 2011 онд, хамгийн их утга 1990 онд тус тус ажиглагджээ. Жилд орсон хур тунадасны 46.7-87.7 % нь VI-VIII саруудад, 12.3-53.3 % нь бусад саруудад ордог.

Хөрсөн бүрхэвч: Хэнтийн аймгийн Дадал сумын төвийн орчмын бүс нутаг нь хөрс-газарзүйн мужлалаар төв Азийн хөрс био уур амьсгалын Хангайн их мужийн Хэнтийн мужийн Хэнтийн зүүн тойрог (өндрийн бүсшилийн хэв шинж бүхий Хангай Хэнтийн мужийн өмнөдийн бүсийн хархүрэн хөрсний 54-р тойрог) багтана (Үндэсний атлас 2009). Тус тойрог ой мод бүхий нам уулсаар уулын нугат хээрийн, уулын ойн ширэгт бараан хөрс, ойн бүсээс доош уулын хээрийн хархүрэн, хүрэн хөрс, уулын бэл, хажуугийн системд уулын карбонатгүй хар шороон хөрс, хүрэн шороон хөрсний хэв шинжүүд ялгарах бол Балж, Баянбулаг голын хөндийд аллювийн ширэгт хөрсний хэв шинжүүд тархсан. Хээрийн судалгааны ажлын хүрээнд төсөл хэрэгжих талбайн хүрээнд уулын ойн сул чандруулаг элсэн хөрс, уулын карбонатгүй хар шороон хөрс, аллювийн ширэгт хөрс, техноген нөлөөлөлд өртсөн хар хүрэн хөрсний хэв шинжүүдийг ялган тодорхойлжээ.

Гадаргын ус болон газрын доорх ус

Хэнтий аймгийн Дадал сумын 4-р багийн нутаг дэвсгэрт хэрэгжих “Чингис хаан аялал жуулчлалын цогцолбор байгуулах” төслийн хээрийн судалгааны ажлыг 2023 оны 04-р сарын 06-08-ны хооронд хийж гүйцэтгэн Хажуу булаг, Баянбулаг голын ус болон Гүний худгийн уснаас дээжлэлт хийж Ханлаб” ХХК-ийн Эрдэс судлал, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. Лабораторийн дүнг “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900-2018” стандарт болон Ундны усны чанарын стандарт MNS 900:2018”-н шаардлага хангаж байна гэжээ Тус шинжилгээний хариунуудаас харахад Химийн

бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 1 р төрлийн чанарын хувьд цэнгэг, маш зөөлөвтөр ус байна.

Ургамлан нөмрөг:

Төслийн талбайд уулын хээрийн жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, бүс дундын голын хөндийн татмын улалж-түнгэт, улалж- алаг өвст гэсэн 3 бүлгэмдэл буйг илрүүллээ. Аялал жуулчлалын цогцолбор байгуулах төв байгууламжуудын орчинд жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст бүлгэмдэл тархсан ба бүлгэмдлийн өнөөгийн төлөв байдал хэвийн. Харин замын дагуух жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст бүлгэмдлийн төлөв байдал бага зэрэг доройтсон төлөв байдалтай байна.

1.3 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

“Мандалт констракшн” ХХК-ийн Хэнтий аймгийн Дадал сумын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх “Чингис хаан аялал жуулчлалын цогцолбор байгуулах” төслөөс байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт болох агаарын чанар, усан орчин, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, нөлөөллийн эрчим, цар хүрээг суурь судалгаа болон хээрийн судалгааны хэмжилтийн мэдээ, лабораторийн дээж шинжилгээнд үндэслэн тодорхойлсныг нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 2. Байгал орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний нэгтгэл

Байгаль орчин	Нөлөөллийн эрчим, цар хүрээ					
	Эерэг			Сөрөг		
	Бага	Дунд	Их	Бага	Дунд	Их
Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл	-	-	-	6	-	-
Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл	-	-	-	3	3	-
Гадаргын болон газрын доорх ус	-	-	-	8	-	-
Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл	-	-	-	4	-	-
Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл	-	-	-	1	2	-
Нийгэм-эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл	-	2	1	-	-	-
ТХГН-т нөлөөлөх нөлөөлөл	-	-	-	1	4	-
Нийт	-	2	1	23	9	-
Хувь	-	5.8	2.8	65.7	25.7	-
Дүгнэлт	Нийт үнэлгээний 25.7% нь дунд зэрэг сөрөг, 65.7% нь бага зэргийн сөрөг, 5.8% нь дунд зэргийн эерэг, 2.8% нь их эерэг нөлөөтэй гэсэн ангилалд хамрагдаж байгааг үндэслэн уг төслөөс байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг “БАГА” гэж үнэлж байна.					

Эдгээр болзошгүй нөлөөллийн нийлбэр дүнгээс үзвэл төслийн барилгын ажлын үе шатанд хог хаягдлын бий болох ахуйн болон барилгын, агаар орчин, хөрс, ургамалд нөлөөлөх нөлөөлөл нь их байгаа нь ажиглагдаж байна. Иймд эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг барилгын ажил бүрэн дуусах 2025 онд төлөвлөж байна.

БҮЛЭГ II. ТУХАЙН ЖИЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1 Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан 2019 оны А/168 тоот “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-г баримтлан боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавин ажилласан.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Чингис хаан аялал жуулчлалын цогцолбор” төслийн үндсэн зорилго нь Эзэн Чингис хааны түүхэн гавьяаг олон улсад үнэн зөвөөр таниулах, Монголын Эзэнт гүрэн, Алтан ургийн хаадын түүхийг өгүүлэх, төрт ёсны өв уламжлалыг таниулах, сурталчлахад орших бөгөөд энэ нь байгалийн үзэсгэлэнт дүр төрх хийгээд өв соёлыг урт хугацаанд дэлхий дахинд таниулах төсөл хөтөлбөр учраас эхлэх цэгээс ахуулан байгаль орчны бүрэлдэхүүн бүрийг нэг бүрчлэн хамгаалах болон олон нийтийг хамруулсан сургалт арга хэмжээ зэрэгцэн үргэлжлэх нь энэ төслийн онцлог юм.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Дадал суманд хог хаягдлын ландфиллийн байгууламж барьсан бөгөөд энэ нь ангилсан хог хаягдлыг хүлээн авах юм. Тиймээс сумын иргэдийг ахуйн хог хаягдлыг ангилан ялгах хэвшилд сургахын тулд 2025 онд сургалтыг зохион байгуулхаар төсөл хэрэгжүүлэгч “Мандалт Констракш”ХХК нь БОМТ-нд тусган ажилж байна. Мөн Уур амьсгалын өөрчлөлт сэдвийн хүрээнд орон нутагт сургалт зохион байгуулах бөгөөд эдгээр ажлуудын үндсэн зорилго нь тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх үндсэн зорилго юм.

2.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Нэгжийн өртөг мян.төг	Нийт зардал мян.төг	Баримтлах хууль эрх зүй, стандарт, аргачлал
1. АГААРЫН ЧАНАР						
Тоос босох угаарын хийн бохирдол үүсэх, физик бохирдолт буюу дуу шуугиан үүсэх	Барилгын хог хаягдлыг төслийн талбайн орчимд цуглуулалгүйгээр төвлөрсөн хогийн цэгт зайлуулах	Барилга байгууламж шинээр барихад 1м ² талбайгаас 0.013 тн хог хаягдал гарахаар заасан байдаг 4522.94м ² барилгажих талбайгаас нийт 58.79 тн хог хаягдал үүсэх бөгөөд хог хаягдлын цэгт нийлүүлэх	2025 онд	-	2500.0	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль; Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2008 Бензин хөдөлгүүртэй авто машин-Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5013:2009 Дизель хөдөлгүүртэй авто машин-Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2009
	Хэт чанга дуут дохио ашиглахгүй байх анхааруулах зөвлөмж техник хэрэгсэл бүрт байршуулах	Техник ажиллах хэсгүүдэд		Үйл ажиллагааны зардлаар		
	Барилгын материал тээвэрлэх үед олон салаа шороон зам гаргахгүй байх чиглэл заасан тэмдэглэгээ байршуулах	Замын маршрут дагуу эргэлт болон зам салах цэг бүрт		150.0	1500.0	
Нийт зардал				4000.0		
2.УСАН ОРЧИН, ГОЛДИРОЛ, ЧАНАР						
Усны нөөц багасах, бохирдол	Ажилчдын унд ахуйн худгийг тоолууржуулах, эрүүл ахуйн бүс тогтоож хамгаалах	-эрүүл ахуйн бүс тогтоож хамгаалах байр барих -Худагт электрон тоолуур суурилуулах	2025 онд	Электрон тоолуур 150.0	2350.0	Монгол Улсын стандарт (MNS 4943-2011), Дэлхийн банкны шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байх шаардлагатай.

		-усны төлбөр төлөх		Хамгаал ах байр 2500.0		Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль “Усан орчны чанарын үзүүлэлт” MNS 4586:1998. ”Газар доорх усыг бохирдлоос хамгаалах” MNS 3342:1982.
	Хажуу булгийн тохижилт хийх	Булгийн тохижилт нь 260х248 хэмжээтэй газрыг хамарсан амралт зугаалах, идэвхтэй ногоон байгууламж бүхий талбай	2025	Төслийн төлөвлөлтөөр		
Усны голдирол өөрчлөгдөх	Хажуу булгийн урсац болон Баянбулаг голын усны хаялгын дээгүүр металл гүүр барихаар төлөвлөсөн байна	Мэдээллийн төвөөс тэнгэрийн орд орох чиглэлд хажуу булгийн урсаж хөндлөн огтлон гарах тул тэр хэсэгт гүүр барих Дэлүүн болдог амрах газарт очих чиглэлд Баянбулаг голыг хөндлөн огтлох тул мөн гүүрэн байгууламж барина	2025 онд	Төслийн төлөвлөлтөөр		
3. ГАЗРЫН ГАДАРГА, ХҮРСЭН БҮРХЭВЧ						
Хөрсөн бүрхэвч устах Хөрсний бохирдол бий болох	Төлөвлөлтөд өртөх талбайн үржил шимт хөрсийг хадгалах	Төслийн төлөвлөлтөөр 4522.9 м² талбай барилагжих бөгөөд суурь ухалтанд өртөх тул үржил шимт хөрсийг хуулж хадгалан орчны	2025	Төлөвлөлтийн зардлаар		Газар шорооны ажлын үед үржил, шимт хөрс хуулалт хадгалалт MNS 5916:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэсэн газрын нөхөн

		тохижилт ногоон байгууламжид ашиглах			сэргээлт: Техникийн ерөнхий шаардлага MNS 5917 : 2008
	Бүтээн байгуулалтын үйл ажиллагааны үед эвдэрсэн, халцгайрсан газруудыг нөхөн сэргээх	Төлөвлөлтөөр шууд нөлөөлөлд өртөх газар байгаа хэдий ч дам нөлөөлөлд өртөх газруудыг нөхөн сэргээх шаардлагатай	-	Төлөвлөлтийн зардлаар	
Нийт зардал				-	
4. АМЬТНЫ АЙМАГ					
Амьтанд гэмтэл учруулах, тоо толгой хорогдох, амьдрах орчин сүйдэх	Төслийн талбайд хөрс шүтэн амьдардаг амьтдын үүр байгаа эсэх үүрэнд төл байгаа эсэхийг шалгаж байж техник ажиллуулах зааварчилгаа өгөх /газар шорооны ажил нь дулааны улиралд хийгддэг тул амьтдын ичээнээсээ гарах болон төллөх үетэй давхцдаг онцлогтой/	Барилга барих болон бусад бүтээн байгуулалт эхлэхээс өмнө хөрс шүтэн амьдардаг амьтдын үүр оромж байгаа эсэхийг техник ажиллах хэсэгт нягтлах, хэрэв байвал өөр тийш зөөвөрлөх / орон нутгийн байгаль хамгаалагчтай нягт хамтран ажиллах/	-	Төлөвлөлтийн зардлаар	Амьтны аймгийн тухай хууль: 6.1.7 дахь заалт: үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан хөнөөгдөхөөс сэргийлэх
	Бүтээн байгуулалтын үед хэт чанга дуут дохио болон шөнийн цагт хурц гэрэлтүүлэг ашиглахгүй байх	Бүтээн байгуулалтын үед хэт чанга дуут дохио болон шөнийн цагт хурц гэрэлтүүлэг ашиглахгүй байх хяналт тавин ажиллах	-		
Жилийн зардал, мян.төг				6350.0	

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

“Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, хамрах хүрээ” MNS 6426:2013 стандартын 5.1.8. Эдэлбэр газрын нийт талбайн 20-с багагүй хувьд ногоон байгууламжтай, хөл газрын ургамалгүй байна гэсэн шаардлагын дагуу нийт төслийн 389 га талбайн 77.8 га -д ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт тохижилтын ажил хийгдэнэ.


Ногоон байгууламж хийж гүйцэтгэхдээ доорх стандартуудыг мөрдлөг болгохоос гадна холбогдох норм нормативыг баримтлан олон наст ургамлын үр, модны суулгацуудын тооцооллыг гаргасан болно.

✓ “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага” MNS 5918:2023

✓ “Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага” MNS 6139:2010

✓ “Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах” MNS 6260:2011

✓ “Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ” MNS 5973:2009



Зураг 2. Орчны тохижилтийн төлөвлөгөө

2.3 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Нэгж зардал мян.төг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт аргачлал
1	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт	Модны суулгац суулгах, цэцгийн мандал тарих, зүлэгжүүлэлт хийх Усалгааны систем Хашаа хамгаалалт	-	/Барилгын ажлын төсөвт орсон/ дотоод зардал		2025 оны хавар намар	MNS 6263:2011 Цэцэрлэгжүүлсэн талбайг шалгаж, ашиглалтад хүлээн - авах. Ерөнхий шаардлага - MNS 5994:2009 Мод, сөөгний үр. Тариалалтын чанар. Техникийн шаардлага - MNS 6253-2:2011 Мод, сөөгний үр тарих. Ерөнхий шаардлага - MNS 5918:2023 Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага. Хамрах хүрээ
2	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд	1800 м ² талбайд нарс 100ш	Мод тарих	6000.0		2025 оны хавар болон намар	
Нийт зардал				16000.0			

2.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Нэгжийн өртөг (мян.төг)	Хариуцагч
1	Төслийн талбайд малчин Э.Тэнүүн-Учрал иргэний 2707 м ² өмчлөх газар хамаарч байна.	Нүүлгэн шилжүүлэлтийн дараах амьжиргаа дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ	25 000.0	“Мотор сервис”ХХК

2.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал төг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	Хажуу булгийн ойролцоох соёлын өвийг хамгаалах	Мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авч хамтран ажиллана	Мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана	1 ш	Дотоод зардлаар		2025 он	Соёлын өвийг хамгаалах тухай хууль

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Төслийн барилга байгууламж барих ажлын явцад ахуйн болон барилгын хог хаягдал гарах бөгөөд “Хог хаягдлын тухай хууль” -ийн хүрээнд “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-ын дагуу зохицуулах ба “Барилга доторх хог хаягдлын менежмент-Ашиглалтын дүрэм” MNS BS 5906:2018 стандартыг мөрдлөг болгон төслийн талбайд ахуйн хог хаягдлыг ангилан ялгалт хийж хаях зориулалтын хогийн цэгүүдийг байршуулан, дахин боловсруулах хог хаягдлыг цуглуулах, бусад барилгын хаягдлыг хог хаягдал тээвэрлэх зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан зайлуулж байхаар төлөвлөж байна. Мөн барилга байгууламж барих бүхий л үе шатанд хог хаягдал үүсгэх эх үүсвэрийг хязгаарлах, бууруулах шаардлага тавьж ажиллахаас гадна өнөө үед дэлхийн чиг хандлагын дагуу 4R зарчмыг баримталж ажиллана.



Зураг 3. 4R зарчим

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тусгасны дагуу барилгын ажлын үед нийт 50 хүн ажиллана гэж үзээд тус барилгын ажлын ажилчдын ахуйн хэрэглээнээс хоногт 25кг, сард 750кг, жилд 9,0тн орчим хатуу хог хаягдал гарах тооцоотой байна. /Тооцоог Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12 сарын 25-ны өдрийн А/368 дугаар тушаалын хавсралт Энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлалын дагуу 1 хүнээс хоногт 0.5 кг хог хаягдал үүсэх/

Харин барилгын материалын үлдэгдэл, хаягдлыг НИТХ-ын 2022 оны 25-р “Барилгын хог хаягдлын менежмент” тогтоолд заасанчлан барилгын 1м² талбайд ногдох барилгын дахин хэрэглэгдэхгүй хог хаягдлын нормативыг БНБД 81-95-12 /2020/ “Барилгын төсөв зохиох дүрэм”-ийн дагуу тооцсон байна. Тус норматив тооцоонд барилга байгууламж шинээр барихад 1м² талбайгаас 0.013 тн хог хаягдал гарахаар заасан байгаа тул төлөвлөлтөд 4522.94м² барилгажих талбайгаас нийт 58.79 тн хог хаягдал үүснэ гэжээ.

Барилга барих үе шатад үүссэн хог хаягдлыг эх үүсвэр дээр БОАЖ-ын Сайдын 2017 оны А/349 дүгээр тушаалын эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, зэрэглэлд хамрагдсанаар ангилан ялгана.

2.6 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	Ахуйн	Ахуйн шингэн хог хаягдал	4.5 м³ багтаамжтай эко нойл (соруулдаг)	1 ш	2500.0	Үйл ажиллагаа эхлэхийн өмнө	Монгол улсын стандарт MNS 5924:2008 “Нүхэн жорлон, угаадасны нүх”-ийн ерөнхий шаардлага Хог хаягдлын тухай хуулийн 10.2.1.энэ хуулийн 9.1.3-т заасан журмын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах;
		хог хаягдлыг ангилан ялгах сав	Төмөр, хуванцар,шил, цаасан хог хаягдалыг тус тусд нь хадгалж 2 догч түүхий эд авах цэгт нийлүүлэх	1ш	1000.0		
2	Барилгын	хог хаягдлын гэрээний дагуу тогтмол хугацаанд ачуулж байх	Гэрээт ХХК-аар тээвэрлүүлэн хог хаягдлын цэгт нийлүүлнэ	Сар бүр	1200.0		
Нийт					4700.0		

2.7 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн зардал мян.төг	Зардал, мян.төг	Баримтлах стандарт ба арга, аргачлал
1. АГААРЫН ЧАНАР					
Агаар дахь тоосжилтын хяналт: Нийт тоос TSP, PM _{2.5} , PM ₁₀ Тоосны уналт Бохирдлын цэгэн эх үүсвэр: SO ₂ , NO ₂ CO, O ₂	-Баригдаж буй барилгуудын ойролцоо (4) -Барилгын материал тээвэрлэлж буй зам - төслийн талбайгаас 100 м зайд салхи доод талд	- Улиралд 1 удаа - зам талбайн тоос дарах ажилд хяналт тавих	шинжилгээний зардал тоос $20.0 \times 6 = 120.0$ агаар $50.0 \times 5 = 250$ багаж түрээс 1500.0	$1870.0 \times 3 = 5610$	Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага: MNS 4585:2007 MNS:4048-88. Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга. MNS 3384-82. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 4585-98. Агаар орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 12.055-91. Ажлын байрны агаар дахь тоосны хэмжээг тодорхойлох Дэлхийн банк. Төрөл бүрийн ажлын орчин дахь дуу шуугианы хязгаарлалтууд, 2007.04.30
Орчны дуу чимээ	-	тээвэрлэлт болон бусад шуугианы эх үүсвэр дээр,	$13.0 \times 10 = 130.0$	$130.0 \times 3 = 390$	
Нийт				6000.0	
2. ГАДАРГЫН БОЛОН ГҮНИЙ УС					
Усны ерөнхий химийн шинжилгээ, pH, TDS (нийт ууссан давс), нийт хатуулаг (CaCO ₃), ууссан хүчилтөрөгч, BXX, XXX, Ca, Mg, Na, K, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ ны агууламж, амт, үнэр, өнгө.	1. Гүний худаг (3) 2. Баянбулгийн гол 3. Хажуу булаг	Улиралд 1	Усны ерөнхий химийн шинжилгээ $98.0 \times 5 \times 3$	1470.0	Усны тухай хууль 2012.05.17 Ундны усны чанарын стандарт MNS 900:2018
3. ХӨРСӨН БҮРХЭВЧ					

Хөрсний химийн шинж чанар, механик бүрэлдэхүүн, хүнд метталл, эрүүл ахуйн шинжилгээ хийлгэх	1. Барилга байгууламжийг барих үед тус талбайн ойролцоо (хөрсний хэв шинжийг харгалцан) 2. Баригдаж буй барилгын ойролцоо () 3. Барилгын материал тээвэрлэж буй зам	Улиралд 1 удаа	Химийн шинжилгээ - 40.0*3*3=360 Хүнд металл 35.0*3*3=315 Эрүүл ахуй 35.0*3*3=315	113.7	“Ариун цэврийн тухай” хууль: 7-р зүйл: 7.4, 7.5 Дээжлэлт хийхдээ MNS:3297:1991 MNS 3473:1983 MNS 4288:1995 MNS 5850:2008
Нэг жилийн орчны хяналт шинжилгээний зардал, мян.төг				7583.7	

2.8 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал Мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Төлөвлөлтийн бусаар газар эвдрэх	Бүтээн байгуулалтын үе шатанд байгаль орчны стандарт шаардлага баримтлах талаар сургалт зохион байгуулах (ажилчдад)	Ажиллах хүчин 50 хүн	-дотоод зардлаар		Улиралд 1
Техник хэрэгсэл эвдрэх тос масло асгарах хөрс бохирдох	Техникийн бүрэн бүтэн байдлыг хангах, гэнэтийн аюул ослоос (гал, түймэр, үер ус) урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн аюулгүй байдлын арга хэмжээний сургалт зохион байгуулах				
Хог хаягдал ил задгай хаях орчныг бохирдуулах	Төслийн хэтийн төлөвлөлтөөр гадаад дотоодын олон жуулчид ирэх учир орон	Дадал сумын иргэд	-	10000.0	Улиралд 1

	нутгийн иргэдийг хог хаягдлаа ангилан ялгах хэвшилд сургах сургалтыг зохион байгуулна				
Малчин өрх айлуудын гол түшиц болсон бэлчээр доройтох	Уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох сургалт зохион байгуулах	Дадал сум болон Хэнтий аймгийн хэмжээнд	Дотоод зардлаар		Жилд 1
БОННУ үр дүн гарахгүй	Байгаль орчны төлөвлөгөөт аудит	2025 оны I улиралд	30 0000		
Нийт зардал			40000.0		

2.9 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээлллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал	Зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
1	“Мандалт Констракшн” ХХК-ийн Байгал орчны мэргэжилтэн - Дадал сумын иргэд - байгаль хамгаалагч - ТХГН-н мэргэжилтэн	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээ хийсэн талаар (ppt) танилцуулна Хийнэ.	2025 онд төслийн үйл ажиллагаанаас үүссэн нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар болон хяналт мониторинг хийсэн тухай, орон нутагтай хамтран ажилласан тухай	2025 оны IV улиралд	Дотоод зардлаар	2 “Мандалт констракшн” ХХК-ийн Байгал орчны мэргэжилтэн	Дадал суманд
Нийт зардал					5000.0		

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрхзүй баримт бичиг, стандарт, журам, дүрэм, Азийн хөгжлийн банкны хамгааллын бодлогын хүрээнд сургалт явуулах, оролцогч талууд, орон нутгийн иргэдийн санал хүсэлтийг тусгахад анхаарч ажиллах юм. Мөн хэрэгжүүлэлтийг барилгын ажлын үйл явцтай уялдуулан, төлөвлөсөн цаг хугацаанд гүйцэтгэхэд чухал ач холбогдол өгч байна.

2025 оны байгаль орчны менежтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийт 104.5 сая.төг зарцуулахаар байна. Үүнд:

- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ -6.3 сая.төг
- Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлт- 16.0 сая.төг
- Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох – 25.0 сая.төг
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө- 4.7сая.төг
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр-7.5 сая.төг
- Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө-40.0 сая.төг
- Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах-5.0 сая.төг